



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 707

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох 4 нэрийн, нийт 426,100,000.00 (дөрвөн зуун хорин зургаан сая нэг зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 269,900,000.00 (хоёр зуун жаран есөн сая есөн зуун мянган) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ц.Амарсанаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,

АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
2021 дугаар тогтоолын хавсралт

**"БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ
ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар	Ашиглалтанд орсон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоосон үнэ	Цаашид ашиглах хугацаа
			(төгрөг)		(жил)
1	Ланд круйзер 200, 07-12 УБЗ	4/1/2014	156,100,000.00	98,300,000.00	3
2	Ланп круйзер 76, 21-70 УНЗ	9/30/2014	90,000,000.00	57,200,000.00	3
3	Ланп круйзер 76, 21-71 УНЗ	9/30/2014	90,000,000.00	57,200,000.00	3
4	Ланп круйзер 76, 21-72 УНЗ	9/30/2014	90,000,000.00	57,200,000.00	3
Дүн			426,100,000.00	269,900,000.00	-
			(дөрвөн зуун хорин зургаан сая нэг зуун мянган)	(хоёр зуун жаран есөн сая есөн зуун мянган)	-